

Астана Олон улсын Санхүүгийн төв

Хураангуй

Төв Ази болон Зүүн Европын бүс нутгийг хамарсан санхүүгийн тэргүүлэх төв болох Казакстан улсын Астана хотод байрлах **Астана Олон Улсын Санхүүгийн төв (АОУСТ)**-ийн талаарх ерөнхий мэдээллийг энэ дугаараараа бид хүргүүлж байна. Евразийн зах зээлд бизнесээ өргөжүүлэхээр сонирхож буй Монгол улсын аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн тоо нэмэгдэж буй энэ цаг үед манай татвар, хуулийн мэдээлэл гарч буйгаа ач холбогдолтой юм.

Англи улсын эрх зүйн зарчимд суурилсан бие даасан эрх зүйн тогтолцоотой, татварын таатай орчинтой, санхүүгийн дэд бүтэц сайтай АОУСТ нь та бүхний бизнесээ Евразийн зах зээлд нэвтрүүлэх боломжийг олгохуйц байршил байж болох юм. Доор АОУСТ-ийн эрхзүйн гол онцлогууд болон санал болгодог татварын хөнгөлөлтүүдийн талаар товчлон танилцууллаа.



АОУСТ-ийн эрхзүйн гол онцлогууд

- ✓ Англи улсын эрх зүйд суурилсан бие даасан хууль эрх зүйн тогтолцоо
- ✓ Маргаан шийдвэрлэх олон улсын арбитрын төв
- ✓ Оршин суугч татвар төлөгчид зориулсан татварын таатай орчин
- ✓ Гадаад ажилтнуудад зориулсан тусгай визний горим, хялбаршуулсан нөхцлүүд
- ✓ Хөрөнгө оруулалтын доод хэмжээний шаардлага байхгүй

АОУСТ-ийн татварын гол хөнгөлөлтүүд (2066 оны 1-р сарын 1 хүртэл):

- Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа (брокерийн үйлчилгээ, исламын банк санхүү, даатгал, давхар даатгал, хөрөнгө оруулалтын менежмент, андеррайтинг гэх мэт)-нд үзүүлэх ААНОАТ болон НӨАТ-ын хөнгөлөлт;
- Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг АОУСТ-ийн бүртгэлтэй этгээдүүдэд хууль эрх зүй, аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид хамаарах ААНОАТ-ын хөнгөлөлт;
- Холдинг компаниудыг оруулаад АОУСТ-ийн бүртгэлтэй этгээдүүдийн хувьцаа, хувь эзэмшлээс олсон ногдол ашгийн орлого, хөрөнгө борлуулсны орлогод үзүүлэх ХХОАТ, ААНОАТ, суутган татвар (СТ)-ын хөнгөлөлт;
- Тодорхой нөхцлүүдийг хангасан тохиолдолд Астана Олон Улсын Бирж ("АОУБ")-д бүртгэлтэй үнэт цааснаас олсон хүү, ногдол ашгийн орлого болон хөрөнгө борлуулсны орлогод үзүүлэх ХХОАТ, ААНОАТ, СТ-ын хөнгөлөлт;
- Хэрэв хувь хүн АОУСТ-ийн хөрөнгө оруулагч оршин суугч бөгөөд Казакстан улсын оршин суугч татвар төлөгч бол Казакстан улсаас өөр улсад олсон орлогод үзүүлэх ХХОАТ-ын хөнгөлөлт;
- Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа болон дээр дурдсан үйл ажиллагаа эрхэлдэг АОУСТ-д бүртгэлтэй этгээдүүдийн гадаад ажилтнуудын орлогод үзүүлэх ХХОАТ-ын хөнгөлөлт гэх мэт.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

Астана Олон улсын Санхүүгийн төв

PwC Казахстан болон PwC Монгол Та бүхэнд хэрхэн туслах вэ?

- ❖ Бизнесийн бүтэц, зохион байгуулалтын чиглэлээр татвар болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, оновчтой бүтцийг бий болгоход туслалцаа үзүүлэх;
- ❖ Нэгдэл, худалдан авалтын үеийн хэлцлийн бүтэц, зохион байгуулалтад туслалцаа үзүүлэх;
- ❖ АОУСТ-д хуулийн этгээдээр бүртгүүлэхэд туслалцаа үзүүлэх болон шаардагдах хугацаа, баримт бичиг болон голлох алхамуудын талаар зөвлөгөө өгөх;
- ❖ АОУСТ-д үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авахад туслах;
- ❖ Хууль болон татварын үүднээс АОУСТ-д бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- ❖ АОУСТ-ийн татварын тогтолцоог хамгийн үр дүнтэйгээр ашиглах талаар зөвлөгөө өгөх;
- ❖ АОУСТ-ийн шаардлагуудыг дагуу татварын тайлагналыг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- ❖ АОУСТ болон бусад төрийн байгууллагуудтай харилцахад дэмжлэг үзүүлэх;
- ❖ Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж (ЕРМ), үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн (CFC) гэх мэт Монгол улсын холбогдох татварын дүрмүүдийг хэрхэн дагаж мөрдөх талаар татварын зөвлөгөө өгөх,
- ❖ АОУСТ-ээс Монгол улс руу ашиг шилжүүлэх ажил гүйлгээнд хамаарах татварын асуудлаар зөвлөгөө өгөх;
- ❖ АОУСТ-ийн хүрээнд болон хил дамнасан бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж буй Монголын бизнесүүдэд Монгол улсын хууль эрх зүйн эрсдлийн үнэлгээ болон нийцлийн магадлан шалгалт хийх.

PwC Казакстан болон PwC Монгол хамтран 2025 оны 9-р сард АОУСТ-ийн талаар танилцуулга вебинар үнэ төлбөргүй, Англи болон Монгол хэл дээр зохион байгуулахаар төлөвлөж байна. Та оролцох сонирхолтой байвал доорх хаягаар бидэнтэй холбогдон, бүртгэлээ хийлгэнэ үү.

Имэйл: nomuun.buyanbayar@pwc.com эсвэл 9986 9777

Имэйл: munkhtelmuun.altantulkhuur@pwc.com эсвэл 9458 2888

Татвар болон Хуулийн мэдээллийг цаашид хүлээн авахыг хүсвэл маягтыг бөглөнө үү.

Маягт

Холбоо барих мэдээлэл:

**Тимур Журсунов**

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

Утас.: +7 (701) 718 20 11

timur.zhursunov@pwc.com**Серги Кобахидзе**


Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

sergi.kobakhidze@pwc.com**Цэндмаа Чойжамц**

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

tsendmaa.choijamts@pwc.com**Алия Ибраева**

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

Утас.: +7 (701) 500 96 72

aliya.ibrayeva@pwc.com**Еркебулан Рахменов**

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

Утас.: +7 (701) 991 14 21

yerkebulan.rakhmenov@pwc.com**Камила Сайлаубаева**

Ахлах Менежер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

Утас.: +7 (705) 992 91 32

kamila.sailaubayeva@pwc.com**Энхзул Жамбал**

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

enkhzul.jambal@pwc.com**Мөнхжаргал Рагчаахүү**

Ахлах Менежер

Хуулийн үйлчилгээ

munkhargal.ragchaakhuu@pwc.com

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болго. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.